

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2015-2030 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

/НҮБ-ын 71 дүгээр Ерөнхий Ассамблейгаас 2017 оны 02 дугаар 02-ны өдөр
батлан гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны шалгуур
үзүүлэлт, холбогдох нэр, томъёоны тайлбар”-аас/

Дэлхийн зорилт:

Зорилт 1. 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшгийн улмаас амь насаа алдагсдын 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд амь насаа алдагсдын тоог бодитой бууруулах

A-1 /нэгдсэн байдлаар/	Гамшгийн улмаас амь насаа алдсан болон сураггүй алга болсон хүний тоо 100,000 хүн тутамд
A-2	Гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоо 100,000 хүн тутамд
A-3	Гамшгийн улмаас сураггүй алга болсон хүний тоо 100,000 хүн тутамд

Зорилт 2. 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшигт нэрвэгдэгсдийн 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд нэрвэгдэгсдийн тоог бодитой бууруулах

B-1 /нэгдсэн байдлаар/	Гамшигт нэрвэгдсэн хүний тоо 100,000 хүн тутамд /шууд/
B-2	Гамшгийн улмаас гэмтэж бэртсэн болон өвчилсөн хүний тоо 100,000 хүн тутамд
B-3	Гамшгийн улмаас орон байр /гэр/ сүйдсэн хүний тоо
B-4	Гамшгийн улмаас орон байргүй, /гэргүй/ болсон хүний тоо
B-5	Гамшгийн улмаас амьжиргаагаа алдсан хүний тоо

Зорилт 3. 2030 он гэхэд гамшгийн улмаас учрах эдийн засгийн шууд хохирлын хэмжээг дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бууруулах

C-1 /нэгдсэн байдлаар/	Гамшгийн улмаас дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөхүйц эдийн засгийн шууд алдагдал
C-2	Гамшгийн улмаас хөдөө аж ахуйн салбарт үүссэн шууд хохирол
C-3	Гамшгийн улмаас бусад үйлдвэрлэлийн салбарт үүссэн эдийн засгийн шууд хохирол
C-4	Гамшгийн улмаас үйлдвэрийн барилга, байгууламж эвдэрч гэмтсэнээс үүссэн эдийн засгийн шууд хохирол
C-5	Гамшгийн улмаас дэд бүтцэд учирсан эдийн засгийн шууд хохирол
C-6	Гамшгийн улмаас түүхийн дурсгалт газар, соёлын өвд учирсан эдийн засгийн шууд хохирол

Зорилт 4. Гамшгийг тэсвэрлэх чадавхийг сайжруулах зэргээр 2030 он гэхэд гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээ түүний дотор боловсрол, эрүүл мэндийн байгууламжид учрах хохирлыг бодитой бууруулах

D-1 /нэгдсэн байдлаар/	Гамшгийн улмаас чухал дэд бүтцэд учирсан хохирол
------------------------	--

D-2	Гамшгийн улмаас нурж сүйдсэн эмнэлэг, эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоо
D-3	Гамшгийн улмаас нурж сүйдсэн боловсролын байгууллагын барилга, байгууламжийн тоо
D-4	Гамшгийн улмаас нурж сүйдсэн чухал дэд бүтцийн байгууламжийн тоо
D-5(нэгдсэн байдлаар)	Гамшгийн улмаас үндсэн үйлчилгээ тасалдсан тоо /нийгмийн/
D-6	Гамшгийн улмаас боловсролын үйлчилгээ тасалдсан тоо
D-7	Гамшгийн улмаас эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ тасалдсан тоо
D-8	Гамшгийн улмаас бусад үндсэн үйлчилгээ тасалдсан тоо

Зорилт 5. 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах

E-1	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитэй улс, орны тоо
E-2	Үндэсний стратегитэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегитэй засаг, захиргаадын тоо

Зорилт 6. 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах

F-1	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F-2	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон талт хамтын ажиллагааны байгууллагаас үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F-3	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F-4	Гамшгийн эрсдэлийг бууруулахад холбогдох технологийг солилцох, шилжүүлэх хүрээнд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F-5	Хөгжиж буй улс орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацийг нэвтрүүлэх, солилцох, шилжүүлэх зорилгоор үзүүлсэн олон улс, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөр, санаачлагын тоо
F-6	Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бий болгох чиглэлээр үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F-7	Хөгжиж буй улс орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бий болгох чиглэлээр үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон

	бусад/
F-8	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд холбогдох статистикийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улс, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөр, санаачлагыг хэрэгжүүлсэн хөгжиж буй улс орны тоо

Зорилт 7. 2030 он гэхэд аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, үнэлгээг ард иргэд хүртэх, ашиглах боломжийг бодитой нэмэгдүүлэх	
G-1 /G2-G5 нэгдсэн байдлаар/	Олон төрлийн аюулын үед эрт зарлан мэдээллийн системтэй улс орны тоо
G-2	Олон төрлийн аюулын мониторинг болон урьдчилан мэдээллэх системтэй улс орны тоо
G-3	Орон нутгийн засаг захиргааны нэгж болон үндэсний мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрт зарлан мэдээлэл хүлээн авдаг хүний тоо 100 000 хүн тутамд
G-4	Эрт зарлан мэдээллийн талаарх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байгаа орон нутгийн засаг захиргааны хувь
G-5	Үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн холбогдох үнэлгээ, мэдээллийг хүртээмжтэй, хэрэглэхэд төхөм, ойлгомжтой байдлаар ард иргэдэд түгээдэг улс орнуудын тоо
G-6	Эрт зарлан мэдээллийн дагуу нүүн шилжиж, болзошгүй гамшгийн эрсдэлээс хамгаалагдсан өртөнги болон эрсдэл өндөртэй хүн амын хувь